



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТОЛООЛОГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 31

Номгон

Төрийн одон медалиар шагнуулах
хүмүүсийн тодорхойлолт өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.8 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Төрийн байгууллага, эрүүл мэнд, боловсрол, мал аж ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ” ЦОЛООР

1. Бадарчийн Амаржаргал Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

“МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ” ЦОЛООР

2. Цагааны Цэрэн Баянхонгор сумын ахмад багш

“АЖ ҮЙЛДВЭРИЙН ГАВЬЯАТ АЖИЛТАЧ” ЦОЛООР

3. Дармаагийн Дашдорж Баянхонгор сумын өндөр настан

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР

4. Жанцангийн Цэдэнсодном Шинэжинст сумын өндөр настан

5. Пагмын Даваа Баянхонгор сумын өндөр настан

6. Сангидоржийн Луумаа Өлзийт сумын өндөр настан

7. Дамдинсүрэнгийн Цэвэгжав Гурванбулаг суманд бага эмч

“АЛТАН ГАДАС” ОДОНГООР

8.Мятавын Жавзандулам	Шинэжинст сумын өндөр настан
9.Нямжавын Тогоохүү	Номундалай цогцолбор сургуулийн багш
10.Одсүрэн Нямчаргиа	Жаргалант сумын өндөр настан
11.Гончигийн Шийрэвсэнгээ	Баянхонгор сумын өндөр настан
12.Манлайн Содной	Заг сумын өндөр настан
13.Чойжингийн Долгорсүрэн	Баянхонгор сумын өндөр настан
14.Маамын Жавхлан	Шинэжинст сумын сувилагч
15.Пилжирийн Наранчимэг	Баацагаан сумын бага эмч
16.Жалбуугийн Пүрэвсүрэн	Хүрээмарал сумын эмийн санч
17.Дээвийн Ичинхорлоо	Жаргалант сумын мэс заслын эмч
18.Дадъяатын Норжин	Нэгдсэн эмнэлгийн тасгийн эрхлэгч
19.Цэрэндорж Мядаг	“Нарбад” эмнэлгийн статистикч эмч
20.Долсүрэнгийн Лхамсүрэн	Шинэжинст сумын малчин

“ ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР

21.Лхагвацэрэнгийн Цэрэн	Чандмань -Баянхонгор ХК-д жолооч
22.Цэдэвийн Мөнхчимэг	Шинэжинст сумын багш
23.Доржийн Алтанцэцэг	Шинэжинст сумын багш
24.Хоролын Даваа	Шинэжинст сумын Эмийн эргэлтийн сангийн эрхлэгч
25.Цэдэвийн Лхамжаз	Шинэжинст сумын асрагч
26.Буниагийн Гантуяа	Шинэжинст сумын ахлах сувилагч
27.Баасангийн Мягмарсүрэн	Баянбулаг сумын бага эмч
28.Түмэнгийн Наранцацрал	Жаргалант сумын сувилагч

- | | |
|------------------------------|---|
| 29.Баасандоржийн Ганцэцэг | Гурванбулаг сумын вакцинолог сувиллагч |
| 30.Дашравдангийн Баяраа | Гурванбулаг сумын сувиллагч |
| 31.Ламрагчаагийн Уламбаяр | Хүрээмарал сумын сувиллагч |
| 32.Цэрэнсономын Амараа | Өлзийт сумынд сувиллагч |
| 33.Цэдэндоржийн Алтанцэцэг | Өлзийт сумын эх баригч бага эмч |
| 34.Төмөрбаатарын Эрдэнэбилэг | Өлзийт сумын дархлаажуулалтын бага эмч |
| 35.Шааравын Жаргалсайхан | Жаргалант сумын статистикч бага эмч |
| 36.Рэнцэнцэдэвийн Гэрэлмаа | Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн тогооч |
| 37.Даваасамбуугийн Байгалмаа | Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч |
| 38.Данзангийн Долгорсүрэн | Нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн сувиллагч |

ДАРГА



Д.ШИРМЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 32

Номгон

Хуралдааны тов хойшлуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дүгээр заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 6 дахь удаагийн сонгуулийн ээлжит ХҮ хуралдааны товыг өөрчлөн 05 дугаар сарын 12-ны өдрийн 10⁰⁰ цагт хуралдуулсугай.

2. Хуралдааны тов хойшлуулсантай холбогдуулж Төлөөлөгчдөд зар хүргэж, хуралдаанаар хэлэлцэх асуудлуудыг 05 дугаар сарын 10-ны дотор Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 33

Номгон

Монгол Улсын Их хурлын болон аймаг,
сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
2012 оны сонгуулийн саналын хуудас
устгах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн 2016 оны 02 дугаар сарын 16-ны эдрийн 36 тоот зөвлөмжийг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их хурлын болон аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2012 оны сонгуулийн саналын хуудсыг устгах ажлыг гүйцэтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Юндэнбазар-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүдэд: В.Эрдэнэчимэг-Аймгийн Төрийн архивын тасгийн дарга

Ц.Мөнхжаргал-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн

Ц.Байгальмаа-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн

Г.Ариунбаяр-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны нягтлан бодогч

Ч.Алтангэрэл-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны жлооч

2. Саналын хуудсыг устгах ажлыг зохион байгуулж, устгасан тухай тэмдэглэлийг Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлэхийг ажлын хэсэг /Д.Юндэнбазар/-т даалгасугай.

ДАРГА



Д.ШИРМЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 35

Номгон

Хөрөнгө барьцаалах
зөвшөөрөл олгох тухай

Хог тээвэрлэлтийн газраас ирүүлсэн саналыг хэлэлцээд Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2-ын 3 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Хог тээвэрлэлтийн газрын 2016 оны хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бэлтгэхэд зориулан тус газрын балансад бүртгэлтэй Ринио-2 автомашиныг банкны зээлийн барьцаанд тавихыг зөвшөөрсүгэй.

2. Зээлийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг 2016 оны IV улиралд багтаан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг Хог тээвэрлэлтийн газар /Д.Ганбат/ -т даалгасугай.

ДАРГА

Д.ШИРМЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 35

Номгон

Эд хөрөнгийн улсын үзлэг
тооллогын тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 439 дүгээр тогтоолыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгах нь:

1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажлыг аймгийн хэмжээнд эсхион байгуулах комиссыг томилсугай.

1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг Сангийн яамнаас ирүүлсэн заавар, аргачлалын дагуу 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 2016 оны 06 дугаар сарын 10-ны хооронд багтаан явуулж, аймгийн нэгдсэн дүнг 2016 оны 06 дугаар сарын 30-ны дотор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж, 2016 оны 07 дугаар сарын 31-ний дотор Сангийн яаманд хүргүүлсүгэй.

2. Орон нутгийн өмчийн албаны 2016 оны төсөвт тусгагдсан эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах зардлаас томилолт, шатахуун, бичиг хэрэг, замын зардал, тооллогын сургалтын зардлыг гаргахыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нягтлан бодогч /Г.Ариунбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Хөрөнгийн улсын үзлэг тооллогын ажилд холбогдох мэргэжлийн хүмүүсийг 3-5 хүртэл хоногийн хугацаагаар татаж ажиллуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

ДАРГА



Д. ШИРМЭН



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 37

Номгон

Хөрөнгийн тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, бүртгэх, дуудлагаар худалдах, шилжүүлэх, актлах журам"-ын 1.6 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТСГТООХ нь:

1. "Чандмань –Баянхонгор" ХК-ний 8756729,44 төгрөгийн хөрөнгийг нэгдүгээр хавсралтаар баталж акталсугай.
2. "Чандмань –Баянхонгор" ХК болон Заг сумын Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа автомашинуудын худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Дуудлага худалдааг 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 11⁰⁰ цагт зохион байгуулж, орлогыг өмчийн албаны 030051009 тоот дансанд төвлөрүүлсүгэй.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ШИРМЭН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын 26 ны
өдрийн 37 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт



ЧАНДМАНЬ БАЯНХОНГОР ХК БОЛОН ЗАГ СУМЫН ЗРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглал- тод ороол огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /мян.км/	Дуудлагаар худалдах доод үнэ	Тайлбар
					сери	дугаар		арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн /см ³ /			
1	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Чиргүүл	ТЧ	АЧ		2003-09-20	моторгүй	моторгүй	моторгүй	100000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
2	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Универсаль-трактор	ЭО-2126	БНА	2076	2006-01-25	131335	6080223	6500	1000000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
3	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Камаз Шланз	Стевр	УБВ	9180	2010-10-15	LZFH19M421 OH03868	107095705	21000	8500000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
4	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	TERKCAN /суудлын/	Террекан	БНА	9809	2010-05-24	KMHNAB1WPR 1V010327	байхгүй	2400	2000000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
5	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК	Hundai 2009 ачааны машин	Хюндай	БНА	92-42	2009-08-25	ES415D2-2	D8AYP09764 5	13500	500000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
6	Заг сум	ЭМТ	УАЗ-469	УАЗ-31595066	БНА	62-40	2006.12.31	60554688	60502769	417-92	1000000.0	Сүүлийн 3 жилд засвар хийгээгүй	
			Дун								13100000.0		

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын
26-ны өдрийн 37 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт

ЧАНДМАНЬ-БАЯНХОНГОР ХК-НИЙ АКТЛАХ
ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /мян.км/	Балансын үнэ	Хуригт-лагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Тайлбар	төгрөгөөр
				сери	дугаар		арлын дугаар	моторын дугаар	моторын эзлэхүүн /см ³ /						
1	Чандмань-Баянхонгор ХК	Мотоцикль /арслан/	Арслан	БНА		2007-07-31	АТ33217	7511256	150	140000	769200.00	769200.00	0.00	Ашиглах боломжгүй	
2	Чандмань-Баянхонгор ХК	Газ-53	Газ 53	БНА	18-01	1986-01-01	1071035	4331	4500	503600	7984529.44	7984529.44	0.00	Ашиглах боломжгүй	
		Дун									8753729.44	8753729.44	0.00		

000



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТОЛООЛОГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 34

Номгон

Аймгийн сүлд уул "Их Богд уул"-ыг
тайх комисс томилох тухай

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 01 дүгээр тогтоолоор баталсан "Их богд уул тахих ёслолын журам"-ын 2.1, 2.2 дахь заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн сүлд уул "Их Богд уул"-ыг тайх ёслолыг 2016 оны 05 дугаар сарын 15-ны биглэгт сайн өдөр үйлдэхээр тогтоосугай
2. Тайх ёслолыг зохион байгуулах комиссыг хавсралтаар баталсугай.
3. Их Богд уулын тахилгад шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.
4. Их Богд уулыг тайх бэлтгэл зохион байгуулалтын төлөвлөгөөг батлуулан, ёслолыг тогтсон хугацаанд үйлдэхийг комисс /О.Тойвгоо/-т даалгасугай.

ДАРГА



Д.ШИРМЭН

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2016 оны 04 дүгээр сарын
26-ны өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралт

**ИХ БОГД УУЛЫГ ТАЙХ ЁСЛОЛЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Комиссын ахлагч: О.Тойвгоо- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: Д.Юндэнбазар-Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

Гишүүдэд: С.Баярмагнай-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргаа
удирдлагын хэлтсийн дарга

Б.Баянжаргал-Гонгандандэдлин хийдийн хамба лам

Г.Батбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн дарга

Д.Ганболд-Богд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга

Л.Ганаа-Богд сумын Засаг дарга

М.Ган-Эрдэнэ-Жинст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга

Н.Жаргалсайхан-Жинст сумын Засаг дарга

Д.Элзиймаа-Баянговь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга

Б.Мөнхсайхан-Баянговь сумын Засаг дарга

О.Мөнхбат-Баянлиг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга

С.Амарсанаа-Баянлиг сумын Засаг дарга

Ч.Очирбат-Аймгийн засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн
хэлтсийн мэргэжилтэн

С.Энхболд-Хөгжимт драмын театрын дарга